



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 536

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай**

“Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийн 8.5, 45, 49 дүгээр зүйлийг тус тус зөрчиж нийт 293,4 сая төгрөгийн, байгууллагын хөрөнгө оруулалт, мөнгөн урсгалыг буруу төлөвлөж хөрөнгийн өгөөжийг бууруулсан зэрэг зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал/Р.Буд/-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

2.2. Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг бодитоор тооцон мөнгөн урсгалыг оновчтой төлөвлөж хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх;

2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай хуулийг мөрдлөг болгож зардалд шингэсэн худалдан авалтыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тайлагнах;

2.4. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн эрх бүхий албан тушаалтан нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.5. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах төлөвлөгөөний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Зардалд шингэсэн худалдан авалтыг төлөвлөгөөнд тусгаагүй	Захирал Р.Буд, Ерөнхий ня-бо Б.Дуламханд	293,404.4	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдаж авах тухай хууль"-ийн 8.5, 45. 49 заалтыг мөрдөж, зардалд шингэсэн худалдан авалтыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ авч биелэлтийг тайлагнах
	Дүн		293,404.4	
			/хоёр зуун ерэн гурван сая дөрвөн зуун дөрвөн мянга дөрвөн зуун/	